СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2022/127-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn<br>Сүхбаатар сум<br>2022 он | ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn<br>Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК<br>Утас: 77270808 Цахим хаяг: Nitsbalance@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт........................................................................**Error! Bookmark not defined.**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ............................ **Error! Bookmark not defined.**

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... **Error! Bookmark not defined.**

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан. **Error! Bookmark not defined.**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ......... **Error! Bookmark not defined.**

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....... **Error! Bookmark not defined.**

3.Аудитын тайлан ....................................................... **Error! Bookmark not defined.**

3.1. Ерөнхий зүйл ..................................................... **Error! Bookmark not defined.**

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .. **Error! Bookmark not defined.**

3.4. Материаллаг байдал......................................... **Error! Bookmark not defined.**

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..................... **Error! Bookmark not defined.**

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт........ **Error! Bookmark not defined.**

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг......... **Error! Bookmark not defined.**

3.8 Аудитын гол асуудал.......................................... **Error! Bookmark not defined.**

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **Error! Bookmark not defined.**

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.......................... **Error! Bookmark not defined.**

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........... **Error! Bookmark not defined.**

4.1 Залруулсан алдаа ................................................ ...**Error! Bookmark not defined.**

4.2 Албан шаардлага, Зөвлөмж........................................................................... 18

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.............................................................................................18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн Газар |
| БШУЯ | Боловсрол Шинжлэх Ухааны Яам |
| НДШ | Нийгмийн Даатгалын Шимтгэл |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/127-НА-СТА-ТШЗ

танай ________ -ны № ________ -т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.ГЭРЭЛМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



018020226

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,716,189.30** | **92,005,894.30** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **0.00** | **0.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **78,716,189.30** | **92,005,894.30** |
| **35100** | **Түүхий эд материал** | **25,200.00** | **25,200.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 25,200.00 | 25,200.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **78,690,989.30** | **91,980,694.30** |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 1,330,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 0.00 | 3,402,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 78,690,989.30 | 87,248,394.30 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,187,698,979.76** | **1,172,892,384.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,187,698,979.76** | **1,172,892,384.83** |
| 39100 | Газар | 0.00 | 0.00 |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,108,548,563.01** | **1,093,944,468.08** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,119,435,506.00 | 1,119,435,506.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -89,331,508.42 | -114,983,373.70 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 0.00 | 0.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 0.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 78,832,498.72 | 60,075,957.72 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -58,316,447.85 | -24,020,732.07 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 51,413,701.48 | 33,883,282.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -43,884,574.19 | -24,833,670.06 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 77,616,422.61 | 75,776,622.61 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -28,861,955.34 | -33,159,044.60 |
| 39217 | Ном | 1,644,920.00 | 1,769,920.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **79,150,416.75** | **78,947,916.75** |
| 39301 | Програм хангамж | 1,660,000.00 | 1,560,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -509,583.25 | -612,083.25 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 78,000,000.00 | 78,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,266,415,169.06** | **1,264,898,279.13** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,266,415,169.06** | **1,264,898,279.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,266,415,169.06** | **1,264,898,279.13** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 442,957,637.20 | 442,957,637.20 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **616,655,010.93** | **616,366,267.84** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 646,928,615.98 | 617,883,157.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -30,273,605.05 | -1,516,889.93 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 206,802,520.93 | 205,574,374.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,266,415,169.06** | **1,264,898,279.13** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **855,260,481.20** | **883,953,458.67** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,345,690.00** | **26,484,253.58** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **5,345,690.00** | **26,484,253.58** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 5,312,250.00 | 20,352,957.58 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 33,440.00 | 6,131,296.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **849,914,791.20** | **857,469,205.09** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **787,232,600.00** | **786,990,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 787,232,600.00 | 786,990,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **305,000.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **62,682,191.20** | **70,174,205.09** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 62,682,191.20 | 70,174,205.09 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **885,534,086.25** | **885,470,348.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **885,534,086.25** | **885,470,348.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **842,558,770.85** | **870,382,099.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **565,854,338.38** | **592,017,301.00** |
| 210101 | Үндсэн цалин | 394,721,300.07 | 419,490,206.59 |
| 210102 | Нэмэгдэл | 132,890,640.36 | 130,584,686.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 38,242,397.95 | 41,942,407.93 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **76,297,324.22** | **80,331,478.74** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,759,195.05 | 55,918,915.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,748,032.61 | 6,139,498.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,521,367.34 | 4,884,678.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,111,911.75 | 1,216,482.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,156,817.47 | 12,171,903.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **62,032,991.20** | **68,321,305.09** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,064,353.70 | 8,634,852.34 |
| 210302 | Түлш, халаалт | 41,093,935.00 | 49,828,227.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,874,702.50 | 9,858,225.75 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,920,740.00** | **9,095,582.78** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,631,800.00 | 2,176,720.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 230,500.00 | 320,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 322,000.00 | 1,962,571.78 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,333,440.00 | 2,698,591.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,283,000.00 | 1,937,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **77,127,910.00** | **73,244,845.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 210,000.00 | 742,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 75,667,510.00 | 72,502,345.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,250,400.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,829,200.00** | **3,472,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,829,200.00 | 3,472,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,191,229.00** | **1,557,434.46** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 867,229.00 | 225,434.46 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 1,332,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **48,305,038.05** | **42,341,452.51** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 875,933.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,941,950.00 | 2,261,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 41,487,155.05 | 40,079,552.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,975,315.40** | **15,088,249.02** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **42,975,315.40** | **15,088,249.02** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,975,315.40 | 15,088,249.02 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-30,273,605.05** | **-1,516,889.93** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **0.00** | **0.00** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-30,273,605.05** | **-1,516,889.93** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **442,957,637.20** | **206,802,520.93** | **646,928,615.98** | **1,296,688,774.11** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **442,957,637.20** | **206,802,520.93** | **646,928,615.98** | **1,296,688,774.11** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **-30,273,605.05** | **-30,273,605.05** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **442,957,637.20** | **206,802,520.93** | **616,655,010.93** | **1,266,415,169.06** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **442,957,637.20** | **206,802,520.93** | **616,655,010.93** | **1,266,415,169.06** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 1,228,146.84 | 1,228,146.84 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **442,957,637.20** | **206,802,520.93** | **617,883,157.77** | **1,267,643,315.90** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | -1,228,146.84 | 0.00 | -1,228,146.84 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -1,516,889.93 | -1,516,889.93 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **442,957,637.20** | **205,574,374.09** | **616,366,267.84** | **1,264,898,279.13** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **849,914,791.20** | **857,469,205.09** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **849,914,791.20** | **857,469,205.09** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **787,232,600.00** | **786,990,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 787,232,600.00 | 786,990,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **305,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 270,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 35,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **62,682,191.20** | **70,174,205.09** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 62,682,191.20 | 70,174,205.09 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **844,860,391.20** | **852,549,205.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **844,860,391.20** | **852,549,205.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **801,885,075.80** | **837,460,956.07** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **565,854,338.38** | **592,017,301.00** |
| 210101 | Үндсэн цалин | 394,721,300.07 | 419,490,206.59 |
| 210102 | Нэмэгдэл | 132,890,640.36 | 130,584,686.48 |
| 210104 | Урамшуулал | 38,242,397.95 | 41,942,407.93 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **76,297,324.22** | **80,331,478.74** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,759,195.05 | 55,918,915.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,748,032.61 | 6,139,498.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,521,367.34 | 4,884,678.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,111,911.75 | 1,216,482.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,156,817.47 | 12,171,903.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **61,852,991.20** | **69,651,305.09** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,064,353.70 | 8,634,852.34 |
| 210302 | Түлш, халаалт | 40,913,935.00 | 51,158,227.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,874,702.50 | 9,858,225.75 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,244,100.00** | **8,601,191.78** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,535,800.00 | 2,176,720.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 410,500.00 | 320,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 322,000.00 | 1,962,571.78 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,300,000.00 | 1,457,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,555,800.00 | 2,684,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **79,114,160.00** | **79,197,145.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 210,000.00 | 742,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 71,250,560.00 | 75,904,645.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,653,600.00 | 2,550,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,829,200.00** | **3,472,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,829,200.00 | 3,472,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,111,262.00** | **1,557,434.46** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 787,262.00 | 225,434.46 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 1,332,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,581,700.00** | **2,632,400.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 955,900.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,625,800.00 | 2,632,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,975,315.40** | **15,088,249.02** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **42,975,315.40** | **15,088,249.02** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,975,315.40 | 15,088,249.02 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **5,054,400.00** | **4,920,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **5,054,400.00** | **4,920,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,054,400.00** | **4,920,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **5,054,400.00** | **4,920,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,054,400.00 | 4,920,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-5,054,400.00** | **-4,920,000.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *|төгрөгөөр|*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **857,196,100.00** | **842,075,956.07** | **15,120,143.93** | **98.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **857,196,100.00** | **842,075,956.07** | **15,120,143.93** | **98.24** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **857,196,100.00** | **842,075,956.07** | **15,120,143.93** | **98.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 592,207,000.00 | **592,017,301.00** | **189,699.00** | **99.97** |
| 210101 | Үндсэн цалин | 395,490,800.00 | 419,490,206.59 | -23,999,406.59 | 106.07 |
| 210102 | Нэмэгдэл | 154,744,400.00 | 130,584,686.48 | 24,159,713.52 | 84.39 |
| 210104 | Урамшуулал | 41,971,800.00 | 41,942,407.93 | 29,392.07 | 99.93 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,378,600.00 | **80,331,478.74** | **47,121.26** | **99.94** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,690,300.00 | 55,918,915.60 | 771,384.40 | 98.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,922,100.00 | 6,139,498.45 | -217,398.45 | 103.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,737,700.00 | 4,884,678.73 | -146,978.73 | 103.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,184,400.00 | 1,216,482.26 | -32,082.26 | 102.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,844,100.00 | 12,171,903.70 | -327,803.70 | 102.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 69,683,200.00 | **69,651,305.09** | **31,894.91** | **99.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,198,400.00 | 8,634,852.34 | 6,563,547.66 | 56.81 |
| 210302 | Түлш, халаалт | 38,969,900.00 | 51,158,227.00 | -12,188,327.00 | 131.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,514,900.00 | 9,858,225.75 | 5,656,674.25 | 63.54 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,416,200.00** | **8,416,191.78** | **8.22** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,180,400.00 | 2,141,720.00 | 38,680.00 | 98.23 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 323,400.00 | 320,000.00 | 3,400.00 | 98.95 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,764,000.00 | 1,962,571.78 | -198,571.78 | 111.26 |
| 210404 | Ном, хэвлэл | 276,500.00 | 120,000.00 | 156,500.00 | 43.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,187,300.00 | 1,187,500.00 | -200.00 | 100.02 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,684,600.00 | 2,684,400.00 | 200.00 | 99.99 |
| **2105** | **Нормативт зардал** | 92,616,000.00 | **79,197,145.00** | **13,418,855.00** | **85.51** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 742,500.00 | 742,500.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 89,321,600.00 | 75,904,645.00 | 13,416,955.00 | 84.98 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,551,900.00 | 2,550,000.00 | 1,900.00 | 99.93 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,272,700.00 | **8,272,700.00** | **0.00** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,800,000.00 | 4,800,000.00 | 0.00 | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,472,700.00 | 3,472,700.00 | 0.00 | **100.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 388,700.00 | **0.00** | 388,700.00 | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 388,700.00 | 0.00 | 388,700.00 | **0.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,601,300.00 | **1,557,434.46** | **1,043,865.54** | **59.87** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 585,300.00 | 225,434.46 | 359,865.54 | 38.52 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,016,000.00 | 1,332,000.00 | 684,000.00 | 66.07 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,632,400.00 | **2,632,400.00** | **0.00** | **100.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,632,400.00 | 2,632,400.00 | 0.00 | 100.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 857,196,100.00 | **842,075,956.07** | **15,120,143.93** | **98.24** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 786,990,000.00 | **771,901,750.98** | **15,088,249.02** | **98.08** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 786,990,000.00 | 771,901,750.98 | 15,088,249.02 | 98.08 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 70,206,100.00 | **70,174,205.09** | **31,894.91** | **99.95** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 70,206,100.00 | 70,174,205.09 | 31,894.91 | 99.95 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 607.00 | **391.00** | **216.00** | **64.42** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | **1.00** | **0.00** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 53.00 | **53.00** | **0.00** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 33.00 | 33.00 | 0.00 | 100.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 500.00 | **284.00** | **216.00** | **56.80** |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 500.00 | **284.00** | **216.00** | **56.80** |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 500.00 | 284.00 | 216.00 | **56.80** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **53.00** | **53.00** | **0.00** | **100.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **305,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **305,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **305,000.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **305,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 35,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 270,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **305,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **305,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 270,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн */цаашид Мандал сумын 3 дугаар цэцэрлэг гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, төлбөрийн баримтыг цахим системд шивэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Эн Ай Ти Эс Аудит" ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 3 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Эн Ай Ти Эс баланс Аудит" ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийг дээдэлж, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх
- СӨБ-ын өдрийн болон явуулын хувилбарт сургалтаар чанартай олгож, хүүхэд бүрийг бүх талаар хөгжүүлэх
- Бага насны хүүхдийг ардын ёс заншилд суралцуулах
- Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсролыг дээшлүүлэх, СӨБ-д олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.
- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" ур чадвар
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл-д-НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 593,495.7 мянган төгрөгөөс *2* хувиар буюу 11,869.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 9,495.9 мянган төгрөгөөр төлөвлөлтийн материаллаг байдлын тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,516.9 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, хөрөнгө, үндсэн хөрөнгө дансууд байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 78,716.2 | 92,005.9 | 13,289.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,187,698.9 | 1,172,892.4 | (14,806.6) |
| **Нийт хөрөнгө** | **1,266,415.2** | **1,264,898.3** | **(1,516.9)** |
| Богино хугацаат өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,266,415.2 | 1,266,415.2 | (1,516.9) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,266,415.2 | 1,264,898.3 | (1,516.9) |

Бараа материалын дансны үлдэгдэл 92,005.9 мянган төгрөг болж 13,289.0 мянган төгрөгөөр өссөн нь түлш, шатах тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,370,501.3 мянган төгрөг болж 38,101.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 4,920.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном худалдан авсан болон БШУЯ-наас 290.1 мянган төгрөгийн тавилга, БСГ-аас 5.0 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүйгээр хүлээн авч аймгийн ОНӨАГ-ын шийдвэрийн дагуу 13,372.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн үнэлгээг бууруулан, сумын ИТХТ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 125 дугаар тогтоолын дагуу 29,944.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,516.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 883,953.5 мянган төгрөг болж өмнөх оноос 28,693.0 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна. Энэ нь орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 885,470.3 мянган төгрөг болж өмнөх оноос 63.8 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 915,084.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 57,888.2 мянган төгрөгөөр бууруулан 857,196.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **857,196.1** мянган төгрөг батлагдсанаас 786,990.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 70,206.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 786,990.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 70,174.2 мянган төгрөг, нийт 857,164.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 842,075.9 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 15,088.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **842,075.9** мянган төгрөг буюу 98.2 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 237.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 31.9 мянган төгрөгөөр, нормативт зардал 13,418.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1,043.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БСУГ-аас 270.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 35.0 мянган төгрөг, нийт 305.0 мянган төгрөгийн орлого төвлөрснийг хангамж, бараа материалын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**1.** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын нэгдүгээр хавсралт “*Короновируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын 3 дугаар цэцэрлэг нь тайлант оны үйл ажиллагаанд 857,196.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 842,075.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.8 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дунд 10-аа с доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,144.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөгдсөнийг бүрэн биелүүлж , шилэн дансны цахим

хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

*Хүснэгт 2.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Албан шаардлага | 1 | 2,144.2 | 1 | 2,144.2 | 100 |
| Зөвлөмж | 1 | | - | | - |
| **Нийт дүн** | **2** | **2,144.2** | **1** | **2,144.2** | **50.0** |

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх ”Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 72,696.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:* Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь баталсан төсөв, төсвийн хэлбэлзлийн тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

1.2. _Өгсөн зөвлөмж:_ Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д: *"санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, ...бүртгэж, тайлагнах*" гэж заасантай нийцэхгүй бөгөөд *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв тайлагнах.

### 2. Төлбөрийн баримттай холбоотой асуудал

*2.1.* _Илрүүлэлт:_ Тайлант онд 72,696.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

*2.2* _Өгсөн зөвлөмж:_ Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"* гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мандал сумын 3 дугаар цэцэрлэг | 2 | 72,696.5 | - | - | - | - | | | 2 | 72,696.5 |